

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhs@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Б.Нэргүй

Утас: 99010744 Цахим хаяг: nerguib82@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ..... 3

 Асуудлыг онцолсон хэсэг..... 3

 Аудитын гол асуудал..... 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 15

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... 17

4. АУДИТЫН ТАЙЛАН..... 17

 4.1 Ерөнхий зүйл 17

 4.2 Материаллаг байдал..... 18

 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 18

 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 18

 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 18

 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... 18

 4.5.1 Завсрын аудитын талаар..... 18

 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... 18

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 19

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... 20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/134
танай _____-ны № _____-т

АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 4,820.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Алаг-Эрдэнэ сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг төлөвлөж, 93.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

9

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	168,066,946.33	199,106,547.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	4,820,600.00
3121	Төгрөг	00.00	4,820,600.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	4,820,600.00
33	АВЛАГА	1,203,468.00	434,895.63
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	434,895.63
335	Бусад авлага	1,203,468.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,203,468.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	166,863,478.33	193,851,051.48
351	Түүхий эд материал	5,195,459.40	6,924,295.40
35110	Тусгай зориулалттай материал	2,623,657.00	5,300,507.00
35130	Эм боох материал	2,571,802.40	1,623,788.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,579,354.17	12,579,354.17
354	Хангамжийн материал	144,328,464.76	169,587,201.91
35410	Бичиг хэргийн материал	25,798,219.46	36,154,779.61
35420	Аж ахуйн материал	65,117,298.40	66,767,298.40
35440	Түлш, шатах тослох материал	24,880,000.00	42,680,000.00
35450	Барилгын засварын материал	12,054,800.00	9,347,000.00
35460	Хүнсний материал	9,981,102.40	8,141,079.40
35470	Бусад хангамжийн материал	6,497,044.50	6,497,044.50
35600	Мал амьтад	4,760,200.00	4,760,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	709,790,051.04	661,412,512.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	709,790,051.04	661,412,512.45
392	Биет хөрөнгө	642,506,051.04	594,128,512.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	711,493,680.00	728,493,680.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-244,025,144.10	-317,445,997.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,000,000.00	26,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,666,666.60	-26,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	271,350,867.56	307,876,287.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-188,735,967.38	-212,865,942.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,521,178.87	144,735,483.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-73,330,265.08	-86,090,885.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,505,000.00	3,505,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,891,624.67	-3,242,124.63
39217	Ном	25,284,992.44	29,163,011.44
393	Биет бус хөрөнгө	67,284,000.00	67,284,000.00
39301	Програм хангамж	1,237,000.00	1,237,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,237,000.00	-1,237,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	67,284,000.00	67,284,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	877,856,997.37	860,519,059.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,308,441.11	7,368,211.98
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,308,441.11	7,368,211.98
413	Өглөг	5,308,441.11	7,368,211.98
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	268,441.11	7,008,211.98
4136	Бусад өглөг	5,040,000.00	360,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,040,000.00	360,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	872,548,556.26	853,150,847.58
51	Засгийн газрын хувь оролцоо	872,548,556.26	853,150,847.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,257,760.70	892,257,760.70
512	Хуримтлагдсан үр дүн	-398,134,457.02	-417,532,165.70
51210	Өмнөх үеийн үр дүн	-398,134,457.02	-398,134,457.02

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,397,708.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	378,425,252.58	378,425,252.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	877,856,997.37	860,519,059.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,095,380,174.92	1,335,720,378.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,902,459.10	43,786,843.91
120	Нийтлэг татварын бус орлого	44,902,459.10	43,786,843.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,902,459.10	39,036,843.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,834,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	44,902,459.10	37,202,243.91
120009	Бусад орлого	00.00	4,750,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	67,896,715.82	139,157,691.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	982,581,000.00	1,152,775,843.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,071,915.82	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,071,915.82	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,824,800.00	139,157,691.70
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,824,800.00	139,157,691.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,146,263,554.21	1,355,118,087.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,146,263,554.21	1,355,118,087.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,489,955.03	1,332,282,107.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,859,872.01	907,713,474.11
210101	Үндсэн цалин	759,266,298.23	867,828,131.49
210102	Нэмэгдэл	29,593,573.78	39,885,342.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,416,020.00	109,859,503.83
210201	Тэтгэврийн даатгал	70,001,499.90	104,025,140.83
210202	Тэтгэмжийн даатгал	620,160.42	5,834,363.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	489,408.35	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	118,631.93	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,186,319.40	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,437,354.82	35,921,369.75
210301	Гэрэл, цахилгаан	7,723,714.82	8,736,369.75
210302	Түлш, халаалт	61,713,640.00	27,185,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,087,450.00	12,312,389.85
210401	Бичиг хэрэг	60,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	6,469,000.00	8,619,339.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	399,500.00	00.00
210404	Ном, хэвлэл	182,900.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	976,050.00	3,693,050.00
2105	Нормативт зардал	36,187,200.20	117,028,637.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,547,961.60	1,927,314.00
210502	Хоол, хүнс	32,639,238.60	115,101,323.00

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,397,708.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	378,425,252.58	378,425,252.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	877,856,997.37	860,519,059.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,095,380,174.92	1,335,720,378.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,902,459.10	43,786,843.91
120	Нийтлэг татварын бус орлого	44,902,459.10	43,786,843.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,902,459.10	39,036,843.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,834,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	44,902,459.10	37,202,243.91
120009	Бусад орлого	00.00	4,750,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	67,896,715.82	139,157,691.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	982,581,000.00	1,152,775,843.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,071,915.82	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,071,915.82	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,824,800.00	139,157,691.70
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,824,800.00	139,157,691.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,146,263,554.21	1,355,118,087.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,146,263,554.21	1,355,118,087.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,489,955.03	1,332,282,107.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,859,872.01	907,713,474.11
210101	Үндсэн цалин	759,266,298.23	867,828,131.49
210102	Нэмэгдэл	29,593,573.78	39,885,342.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,416,020.00	109,859,503.83
210201	Тэтгэврийн даатгал	70,001,499.90	104,025,140.83
210202	Тэтгэмжийн даатгал	620,160.42	5,834,363.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	489,408.35	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	118,631.93	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,186,319.40	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,437,354.82	35,921,369.75
210301	Гэрэл, цахилгаан	7,723,714.82	8,736,369.75
210302	Түлш, халаалт	61,713,640.00	27,185,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,087,450.00	12,312,389.85
210401	Бичиг хэрэг	60,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	6,469,000.00	8,619,339.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	399,500.00	00.00
210404	Ном, хэвлэл	182,900.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	976,050.00	3,693,050.00
2105	Нормативт зардал	36,187,200.20	117,028,637.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,547,961.60	1,927,314.00
210502	Хоол, хүнс	32,639,238.60	115,101,323.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,057,430.00	13,351,250.00
210604	Урсгал засвар	9,057,430.00	13,351,250.00
2107	Томилолт, зочны зардал	599,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	599,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,565,500.00	5,774,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,965,500.00	1,834,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,939,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,279,928.00	130,321,182.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	12,293,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,198,350.00	3,032,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,081,578.00	114,995,282.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,773,599.18	22,835,980.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,944,120.90	19,078,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,944,120.90	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	19,078,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,617,967.28	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,617,967.28	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,211,511.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,211,511.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,757,180.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,757,180.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-50,883,379.29	-19,397,708.68
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,183,253.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,183,253.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,183,253.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-56,066,632.29	-19,397,708.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,050,477,715.82	1,298,518,134.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	6,584,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	6,584,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,834,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,834,600.00
120009	Бусад орлого	00.00	4,750,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,050,477,715.82	1,291,933,534.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	982,581,000.00	1,152,775,843.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,071,915.82	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,071,915.82	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,824,800.00	139,157,691.70

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,824,800.00	139,157,691.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,033,673,915.82	1,264,282,034.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,033,673,915.82	1,264,282,034.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	984,141,948.54	1,193,429,754.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763,440,353.34	899,742,321.67
210101	Үндсэн цалин	503,497,291.23	675,995,888.05
210102	Нэмэгдэл	217,235,687.18	181,059,758.60
210104	Урамшуулал	42,707,374.93	42,686,675.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,868,349.38	111,291,313.03
210201	Тэтгэврийн даатгал	68,388,767.49	75,348,613.03
210202	Тэтгэмжийн даатгал	7,392,135.46	8,985,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,910,428.37	7,188,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,469,301.64	1,797,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,707,716.42	17,971,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,373,714.82	58,401,369.75
210301	Гэрэл, цахилгаан	7,723,714.82	8,388,641.60
210302	Түлш, халаалт	38,650,000.00	49,665,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	347,728.15
2104	Хангамж, бараа материалын зардал	10,914,700.00	00.00
210401	Бичиг хэрэг	399,500.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	7,438,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	399,500.00	00.00
210404	Ном, хэвлэл	332,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	279,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,065,200.00	00.00
2105	Нормативт зардал	33,249,324.00	65,245,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,333,194.00	00.00
210502	Хоол, хүнс	30,267,230.00	65,245,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	648,900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,020,800.00	10,643,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,756,000.00	00.00
210602	Тавилга	9,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	15,264,800.00	10,643,450.00
2107	Томилолт, зочны зардал	599,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	599,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,477,500.00	5,774,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,877,500.00	1,834,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,939,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,198,007.00	42,332,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	31,325,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,198,007.00	11,007,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,531,967.28	70,852,280.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,702,489.00	67,095,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,702,489.00	48,016,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	19,078,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,617,967.28	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,617,967.28	00.00

Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,211,511.00	3,757,180.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,211,511.00	3,757,180.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,803,800.00	34,236,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,050,000.00	29,415,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,050,000.00	29,415,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,050,000.00	29,415,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,050,000.00	29,415,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-16,050,000.00	-29,415,500.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	753,800.00	4,820,600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,820,600.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-326,710,936.10	943,974,477.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	2,400.00	2,400.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,257,760.70	-326,708,536.10	943,976,877.18
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-56,066,632.29	-56,066,632.29
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-398,134,457.02	872,548,556.26
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-398,134,457.02	872,548,556.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,257,760.70	-398,134,457.02	872,548,556.26
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,397,708.68	-19,397,708.68
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-417,532,165.70	853,150,847.58

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/Төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,154,539,100.00	1,149,718,600.00	4,820,500.00	99.58

21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,154,469,200.00	1,149,718,600.00	4,820,500.00	99.58
210	Бараа, үйлчилгээний зардал	1,087,444,000.00	1,082,623,500.00	4,820,500.00	99.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	835,428,100.00	836,457,386.97	(1,029,286.97)	100.12
210101	Үндсэн цалин	621,435,600.00	615,048,312.50	6,387,287.50	98.97
210102	Нэмэгдэл	178,422,000.00	178,722,399.45	(300,399.45)	100.17
210104	Урамшуулал	35,570,500.00	42,686,675.02	(7,116,175.02)	120.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,428,500.00	103,399,313.03	1,029,186.97	99.01
210201	Тэтгэврийн даатгал	71,011,400.00	69,982,113.03	1,029,286.97	98.55
210202	Тэтгэмжийн даатгал	8,344,600.00	8,354,300.00	(9,700.00)	100.12
210203	ҮОМШӨ ний даатгал	6,654,700.00	6,683,400.00	(28,700.00)	100.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1,757,100.00	1,670,900.00	86,200.00	95.09
210205	Эрүүл мэндийн даатгал	16,660,700.00	16,708,600.00	(47,900.00)	100.29
2105	Нормативт зардал	65,245,000.00	65,245,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	65,245,000.00	65,245,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,172,600.00	5,774,300.00	3,398,300.00	62.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,834,600.00	1,834,600.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	7,338,000.00	3,939,700.00	3,398,300.00	53.69
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	73,169,800.00	71,747,500.00	1,422,300.00	98.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,162,800.00	60,740,500.00	1,422,300.00	97.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,007,000.00	11,007,000.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,095,100.00	67,095,100.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,095,100.00	67,095,100.00	-	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	48,016,300.00	48,016,300.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	19,078,800.00	19,078,800.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,154,469,200.00	1,154,469,200.00	-	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,154,539,200.00	1,154,539,200.00	-	-
131007	Улсын төсвийн санхүүжих	1,152,634,600.00	1,152,634,600.00	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН	1,904,600.00	1,904,600.00	-	100.00

Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,904,600.00	1,904,600.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,820,600.00	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-			-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	69.00	69.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	42.00	42.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	26.00	26.00	-	100.00

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	139,149,100.00	135,391,919.75	3,757,180.25	97.3
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	139,149,100.00	135,391,919.75	3,757,180.25	97.3
210	Бараа, үйлчилгээний зардал	139,149,100.00	135,391,919.75	3,757,180.25	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,135,100.00	63,135,100.00		
				0.00	100.0
210101	Үндсэн цалин	63,135,100.00	60,797,740.85	-2,337,359.15	96.3
210102	Нэмэгдэл	-	2,337,359.15	-2,337,359.15	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,892,000.00	7,892,000.00		100.0
210201	Тэтгэврийн даатгал	5,366,500.00	5,366,500.00		100.0
210202	Тэтгэмжийн даатгал	631,400.00	631,400.00		100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	505,100.00	505,100.00		100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	126,300.00	126,300.00		100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,262,700.00	1,262,700.00		100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,400,000.00	53,721,369.75	1,678,630.25	96.9
210301	Гэрэл цахилгаан	10,000,000.00	8,736,369.75	1,263,630.25	83.8
210302	Түлш, халаалт	45,000,000.00	44,985,000.00	15,000.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	0.00	400,000.00	0.00
2106	Эд хогшил худалдан авах	12,722,000.00	10,643,450.00	2,078,550.00	83.6
210604	Урсгал засвар	12,722,000.00	10,643,450.00	2,078,550.00	83.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	139,149,100.00	135,391,919.75	3,757,180.25	97.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	139,149,100.00	135,391,919.75	3,757,180.25	97.3
132001	Орон нутгийн төсвөөс	139,149,100.00	135,391,919.75	3,757,180.25	97.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	-

2.5.3 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,680,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,680,000.00
210	Бараа, үйлчилгээний зардал	4,680,000.00
210302	Түлш, халаалт	4,680,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,680,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,680,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,680,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд “Эрүүл зөв дадал, эерэг хандлага, бүтээлч оролцоог хэвшүүлж сургалтын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Алаг-Эрдэнэ сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг төлөвлөж, 93.1 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу сургуулийн захирлын 2022 оны А/48 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр сард батлуулан, тухайн онд нийт 5 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлж, тайлагнасан боловч дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм,

журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон татвар, нийгмийн даатгалын байгууллагуудаас хяналт шалтгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,337.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	4,820.6	4,820.6
Авлага	1,203.5	434.9	(768.6)

Бараа материал	166,863.5	193,851.1	26,987.6
Үндсэн хөрөнгө	709,790.1	661,412.5	(48,377.5)
Нийт хөрөнгө	877,857.0	860,519.1	(17,337.9)
Өр төлбөр	5,308.4	7,368.2	2,059.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	872,548.6	853,150.8	(19,397.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	877,857.0	860,519.1	(17,337.9)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, өр төлбөр, өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, авлага, эздийн өмчийн данс данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,820.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 26,987.6 мянган төгрөгөөр нэмэгдэхэд түлээний нөөц нэмэгдсэн /түлээний үнийн өсөлт/ нөлөөлсөн байна.
3. Өр төлбөр 7,368.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь цалингаас суутгасан ХОАТ 7,008.2 мянган төгрөг, бусад өр төлбөр 360.0 мянган төгрөг байна.
4. Авлага дансны үлдэгдэл 434.9 мянган төгрөг байгаа нь үйлдвэрчний эвлэлийн татварын тооцооны үлдэгдэл байна.
5. Үндсэн хөрөнгө данс 48,377.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 66,617.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 114,995.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,203,634.4 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийн саналаас 335,701.1 мянган төгрөгөөр бууруулан 867,933.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн төлөвлөлтийг зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөснийг УИХ-аар үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгохоор баталсантай холбоотой, төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр удаа дараа нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: Байгууллагын 2022 оны төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 115,179.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Ингэснээр нийт төсвийн зарлага 1,154,469.2 мянган төгрөг болж, 1,152,634.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 1,904.6 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталжээ.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

